

АУДИТЫН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

1. Компанийн товч танилцуулга.

1.1 Товч танилцуулга:

“Дархан Нэхий” ХК нь анх 1972 онд Засгийн газар хоорондын шийдвэрээр нэхий эдлэлийн үйлдвэрийг байгуулан ажиллаж эхлэсэн ба МУ-ын засгийн газрын өмч хувьчлалын комиссын 1992 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 43 дугаар тогтоолоор хувьцаат компани болгон зохион байгуулагдсан байна.

1.3 Компанийн үйл ажиллагааны зорилго, зорилт:

Олон улсын чанар стандартын түвшинд хүрсэн, зах зээлд өрсөлдөх чадвар сайтай, арьс шир болон түүгээр хийсэн бүтээгдэхүүнийг шинэ болон шинэчилсэн технологиор үйлдвэрлэж, дотоод, гадаадын зах зээлд борлуулна гэсэн эрхэм зорилготойгоор ажиллаж байна.

Тус компани тайлант хугацаанд арьс шир боловсруулах, гутал, хувцас оёдлын үйлдвэрлэл, үйлдвэрлэл, худалдаа, худалдаа үйлчилгээ, түрээс, зочид буудлын үйлчилгээ, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, зээлийн үйлчилгээ үзүүлэх зэрэг үйл ажиллагаагаа явуулж байна.

1.4 Цар хүрээ:

Нэхий Таннери ХХК арьс шир боловсруулах үйлдвэрлэл, Нэхий гармет ХХК гутал, хувцас оёдлын үйлдвэрлэл, Як трейд ХХК үйлдвэрлэл, худалдаа, Нэхий трейд ХХК сүлжээ дэлгүүр, худалдаа үйлчилгээ, Гранд як ХХК түрээс, зочид буудлын үйлчилгээ, Нэхий агр ХХК хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, Дэвжих нэхий ХХК зээлийн үйлчилгээ үзүүлдэг компаниудыг 100 хувь эзэмшдэг байна.

2. Санхүүгийн тайлан бэлтгэсэн үндэс

а) Санхүүгийн тайлангийн нийцэл

Компанийн санхүүгийн тайлан нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын (СТОУС)-ууд болон Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартуудад нийцүүлэн Сангийн Сайд-ын 2017 оны 361 тоот тушаалаар батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагад мөрдөгдөх санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар, журмын”-ын дагуу бэлтгэсэн байна.

б) Санхүүгийн тайлан бэлтгэсэн үндэслэл

Компанийн санхүүгийн тайлангууд нь түүхэн өртөг суурилсан болно. Компани нь мөнгөн гүйлгээнээс бусад санхүүгийн тайлангийн бүрэлдхүүнийг аккрузал суурьд үндэслэн бэлтгэсэн.

в) Санхүүгийн тайлангийн тайлагнах валют

Санхүүгийн тайлангуудыг үндэсний мөнгөн тэмдэгт мянган төгрөгөөр илэрхийлсэн. Аудитлагдсан санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийн үлдэгдлийг балансын эхний үлдэгдэлтэй зэрэгцүүлэн тайлагнасан.

г) Компанийн тасралтгүй байх зарчим

2019 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан нь тасралтгүй байх зарчим дээр үндэслэгдсэн.

Компанийн үйл ажиллагаа тасралтгүй үргэлжлүүлэх эсэх нь санхүүжүүлэгчид ба хувь нийлүүлэгчдийн үзүүлэх дэмжлэгээс хамаарна. Хувь нийлүүлэгчдээс дэмжлэг авахгүй байх тохиолдлын нөлөөллийн залруулгуудыг энэхүү санхүүгийн тайланд тусгаагүй болно.

3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого

1. Ашиглаж буй санхүүгийн программ болон хяналтын талаар

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ "exsel" программын ашигладаг.

Компанийн үйл ажиллагаа, үйлдвэрлэлд Төлөөлөн удирдах зөвлөл, Захиргааны гишүүдийн хурал зэргээс зохих түвшний байнгын хяналт тавьж ажилладаг.

2. Нягтлан бодох бүртгэлийн тусгайлсан бодлогууд

а) Мөнгөн хөрөнгө

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө нь банкин дахь харилцах болон бэлэн мөнгөний үлдэгдлээс бүрддэг. Мөнгөн хөрөнгийг нэрлэсэн үнээр бүртгэсэн.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн хөрөнгийн гүйлгээ, үлдэгдлийг балансын өдрөөрх Монголбанкны албан ханшаар төгрөгт хөрвүүлэн бүртгэж, зөрүүг орлогын тайланд тусгасан байсан.

б) Дансны авлага

Дансны авлагыг хүлээн авахаар тооцсон анхны цэвэр боломжит дүнгээр үнэлж, бүртгэгдсэн.

Тайлант жилд дансны авлагын үлдэгдэлд найдваргүй авлагын хасагдуулга тооцоогүй байна.

е) Өглөг, өр төлбөр

Өглөг, өр төлбөр нь бараа ажил үйлчилгээ худалдан авсны төлөө хүлээж буй хариуцлага бөгөөд ирээдүйд төлөх бодит өртгөөрөө тусгагдана.

ж) Эзэмшигчдийн өмч

Эзэмшигчийн өмчид оруулсан болон олсон капиталын нийлбэрээр илэрхийлэгдсэн.

з) Орлого хүлээн зөвшөөрөлт

Орлогыг үнэн зөв тодорхойлох боломжтой болон эдийн засгийн үр ашиг нь байгууллагад орох нь тодорхой болсон үед буюу худалдан авагчдад бүтээгдэхүүн нийлүүлсэн, ачуулсан дүнгээс борлуулалтын хөнгөлөлт, буцаалт, нэмэгдсэн өртгийн татвар хассан цэвэр дүнгээр хүлээн зөвшөөрч, аккруэл сууриар бүртгэсэн.

и) Зардал хүлээн зөвшөөрөлт

Борлуулсан бүтээгдэхүүний өртөг нь борлуулалтын орлогод ногдох борлогдсон барааны өртөг юм. Өртгийн төвүүдээс бүтээгдэхүүний тоо хэмжээнд суурилан бэлэн бүтээгдэхүүнд хувиарлагдсан өртөгт үндэслэн борлуулсан бүтээгдэхүүний өртгийг тооцдог.

Компанийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагаатай холбогдож гарсан бүх зардлыг орлогын тайланд тусгадаг бөгөөд эдгээр зардлыг аккруэл сууриар бүртгэсэн.

к) Мөнгөн гүйлгээний тайлан

Мөнгөн гүйлгээний тайлан нь тайлангийн хугацааны туршид гарсан үндсэн болон хөрөнгө оруулалтын, санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээг харуулдаг.

л) Санхүүгийн хэрэглүүр

Тус компанийн хувьд мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө, дансны авлага, өглөг нь санхүүгийн хэрэглүүр болдог.

Тодорхой нэг төрлийн санхүүгийн хэрэглүүрийг олж авахад хийгдсэн гэрээний эрх дээр үндэслэн, уг гэрээг байгуулах үйл ажиллагааны зардлыг тооцож оруулсан анхны өртгөөр тус санхүүгийн хэрэглүүрийг бүртгэлд тусгадаг.

в) *Бараа материал*

Бараа материалын өртөгт худалдан авалтын өртөг, өөрийн эзэмшилд авчрахтай холбогдож гарсан бусад зардлуудыг оруулдаг.

Бусад бараа материалыг байнгын системээр бүртгэсэн ба дундаж өртгийн аргыг ашиглан зарлага болгосон.

Үйлвэрлэл үйлчилгээний зардлыг шууд материал, шууд хөдөлмөр, үйлдвэрлэлийн нэмэгдэл зардал гэж ангилан үйлдвэрлэлийн болон үйл ажиллагааны цех тасаг, нэгж бүрээр хуримтлуулан бүртгэдэг.

г) *Үндсэн хөрөнгө*

1.Хүлээн зөвшөөрөлт ба хэмжигдхүүн

Үндсэн хөрөнгө нь анхны өртгөөс хуримтлагдсан элэгдлийг хассан үлдэгдэл өртгийн дүнгээр илэрхийлэгдсэн.

Үндсэн хөрөнгийг орлого болгох анхны өртөгт худалдан авсан үнэ, түүнийг бэлтгэхтэй холбогдон гарсан бүх зардлын нийт дүнг оруулан тооцдог.

Үндсэн хөрөнгийг зарлага болгохдоо түүний анхны өртөг ба хуримтлагдсан элэгдлийг данснаас хасах бөгөөд тухайн хөрөнгийг данснаас хассанаас үүссэн олз, гарзыг орлогын тайланд цэвэр дүнгээр тусгадаг.

2.Элэгдэл

Үндсэн хөрөнгөнд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулинд заасан ашиглалтын хугацааг баримтлан шулуун шугамын аргаар элэгдэл тооцдог.Үүнд:

Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж	10 жил
Тээврийн хэрэгсэл	10 жил
Компьютер, дагалдах хэрэгсэл	3 жил
Тавилга, эд хогшил	10 жил

Элэгдэл тооцох арга, ашиглах хугацаа, үлдэх үнэ цэнийг тайлан бэлтгэн гаргах бүрдээ хянаж үздэг байна.

Ашиглагдаж байгаа үндсэн хөрөнгөнд хийсэн засвар үйлчилгээний болон нөхөн сэргээхтэй холбогдож гарсан зардлуудыг, үндсэн хөрөнгийг ашигласнаас олно гэж хүлээж байгаа ирээдүйн эдийн засгийн ашгийг анх тогтоосон гүйцэтгэлээс нэмэгдүүлэхэд хүргэсэн зардлууд гэж тодорхойлж болох нөхцөлд уг зардлуудыг үндсэн хөрөнгийн нэмэлт өртөг болгож капиталжуулдаг.

д) *Хөрөнгө оруулалт*

Хөрөнгө оруулалтыг худалдан авсан нийт дүнгээр нь буюу өмчийн аргаар бүртгэдэг.

м) Орлогын татвар

Компанийн тайлант үеийн орлогын татварын зардал нь тухайн жилийн татвар ногдуулах орлогод ногдох балансын өдөр үйлчилж буй татварын хувь хэмжээгээр тооцох бөгөөд өмнөх жилүүдийн татварын өглөгийг тохируулсан хүлээгдэж буй татварын өглөг юм.

4. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийн тухай

4.1. Тодруулга - Мөнгөн хөрөнгө

Үзүүлэлт		2018.12.31	2019.12.31
Касс:	Төгрөг	4,896.4	5,691.4
Харилцах:	Төгрөг	1,087,220.0	444,730.9
	Ам.доллар	48,783.0	7,583.4
<i>Дүн (мянган төгрөг)</i>		<i>1,140,899.4</i>	<i>458,005.7</i>

Тайлант хугацааны эцсийн үлдэгдэл нь тайлант хугацааны цэвэр мөнгөн гүйлгээгээр нэмэгдсэн.

4.2. Тодруулга – Дансны авлага

Үзүүлэлт		2018.12.31	2019.12.31
Дансны авлага		2,176,372.6	2,666,077.8
Гаргасан зээл		1,988,732.5	3,238,470.0
Зээлийн хүүгийн авлага		317,829.0	349,911.0
Илүү төлсөн татвар		248,411.8	192,103.6
Бусад авлага		135,775.2	134,037.8
<i>Дүн (мянган төгрөг)</i>		<i>4,866,761.1</i>	<i>6,580,600.2</i>

Нийт авлагын 49.2 хувийг Дэвжих нэхий ББСБ-ын гаргасан зээлийн авлага, 40.5 хувийг бэлтгэн нийлүүлэгчдээс авах авлага, Голомт банкны зээлийн хүүгийн авлага, 5.4 хувийг зээлийн хүүгийн авлага, 0.9 хувийг НӨАТ-ын авлага, 2.0 хувийг ААНОАТ-ын авлага, 2.0 хувийг харилцагч хувь хүн байгууллагуудаас авах авлага тус тус эзэлж байна.

4.3. Тодруулга – Бараа материал

Үзүүлэлт		2018.12.31	2019.12.31
Түүхий эд материал		704,086.0	422,843.0
Бэлэн болон арьс		1,899,916.0	2,148,884.3
Бэлэн бүтээгдэхүүн		3,081,701.2	4,630,618.3
Дуусаагүй үйлдвэрлэл		3,159,182.8	4,096,411.1
Хүнсний бараа		1,457,615.4	1,425,912.0

Барилгын материал	126,878.6	6,598.7
Сэлбэг материал	119,786.0	124,776.7
Оёдлын туслах материал	559,672.7	755,972.8
Химийн материал	1,807,284.0	1,247,436.4
Аж ахуйн материал	43,174.8	27,125.3
<i>Дүн (мянган төгрөг)</i>	<i>12,959,297.5</i>	<i>14,886,578.6</i>

Тайлант хугацааны эцэст бараа материалын үлдэгдэл өмнөх оны мөн үеийн үлдэгдэлээс 1,927,281.1 мянган төгрөгөөр өссөн ба бараа материалын үлдэгдлийг ерөнхий захирлын тушаалаар батлагдсан тооллогын комисс тоолж баталгаажуулсан ба тооллогоор зөрүү үүсээгүй байна.

4.4. Тодруулга - Үндсэн хөрөнгө

а). Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	2018.12.31	2019.12.31
Газрын сайжруулалт	219,869.6	212,384.4
Барилга байгууламж	22,850,285.3	23,024,359.8
Машин тоног төхөөрөмж	4,983,393.0	4,464,030.8
Компьютер тоног төхөөрөмж	60,769.8	37,760.2
Тавилга эд хогшил	173,651.3	176,564.7
Биет бус хөрөнгө	24,999.3	45,552.8
Тээврийн хэрэгсэл	41,733.9	33,948.2
Бусад хөрөнгө	25,164.8	17,376.7
Биологийн хөрөнгө	400.0	
Дуусаагүй барилга	6,222,867.9	9,031,468.0
Урт хугацаат хөрөнгө оруулалт	1,690,220.0	1,000.0
<i>Дүн (мянган төгрөг)</i>	<i>36,293,354.9</i>	<i>37,044,445.6</i>

Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүйг ангилал тус бүрээр харуулбал дараах байдалтай байна.

Тайлант хугацаанд 1,055,273.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, 97,076.2 мянган төгрөгийн хөрөнгө данснаас хассан байна.

б). Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл:

Үзүүлэлт	2018.12.31	2019.12.31
Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл	7,009,206.4	8,339,322.5
Бусад хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл	23,975.8	38,933.0
<i>Дүн (мянган төгрөг)</i>	<i>7,033,182.2</i>	<i>8,378,255.5</i>

4.7. Тодруулга - Богино хугацаат өглөг

Үзүүлэлт	2018.12.31	2019.12.31
Дансны өглөг	1,377,965.7	1,311,720.5

Цалингийн өглөг	3,751.0	145,350.5
Орлогын татварын өглөг	207,394.4	445,841.5
ХХОАТ-ын өглөг	79,736.7	280,847.5
НӨАТ-ын өглөг	458,642.5	1,015,545.2
Бусад татварын өглөг	143,768.7	285,819.7
ЭМ, НДШ-ийн өглөг	98,281.3	434,025.9
Урьдчилж орсон орлого	1,585,766.5	3,793,916.1
Бусад өглөг	8,052.6	31,959.3
<i>Дүн (мянган төгрөг)</i>	<i>3,963,359.4</i>	<i>7,745,026.2</i>

Нийт богино хугацаат өр төлбөрийн 26.2 хувийг татварын өглөг, 48.9 хувийг урьдчилж орсон орлого, 16.9 хувийг дансны өглөг, 1.8 хувийг цалингийн өглөг, 5.6 хувийг ЭМ НДШ-ийн өглөг, 0.6 хувийг бусад өглөгийн үлдэгдэл тус тус эзэлж байна.

Урьдчилж орсон орлого дансны үлдэгдэл нь худалдан авагч байгууллагуудаас орсон бараа борлуулалтын орлого байна.

Түүхий эд бэлтгэх болон хөрөнгө оруулалтын зориулалтаар Азийн хөгжлийн банк, болон харилцагч банкуудаас авсан 1,199,040.8 мянган төгрөгийн зээлийг богино хугацаат өр төлбөрөөр, 10,295,048.7 мянган төгрөгийг зээлийг урт хугацаат өр төлбөрөөр тайлагнасан.

Зээлийн дансны үлдэгдлийг дэлгэрэнгүй харуулбал дараах байдалтай байна.

Үзүүлэлт	<i>(мянган төгрөг)</i>	
	2018.12.31	2019.12.31
Засгийн газрын хөнгөлөлттэй зээл	2,150,000.0	
Азийн хөгжлийн банкны зээл	4,100,000.0	4,028,070.2
Худалдаа хөгжлийн банкны зээл	1,987,312.0	1,266,978.5
Голомт банк		302,000.0
Хаан банк		5,897,040.8
<i>Дүн (мянган төгрөг)</i>	<i>8,237,312.0</i>	<i>11,494,089.5</i>

4.8. Тодруулга - Эзэмшигчдийн өмч

Үзүүлэлт	2018.12.31	2019.12.31
Өмч:		
Хувийн өмч	5,259,944.0	3,753,574.9
Халаасны хувьцаа	(16,428.5)	(16,428.5)
Нэмж төлөгдсөн капитал	(106,648.6)	(106,648.6)
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	19,334,524.6	19,334,524.6
Эздийн өмчийн бусад хэсэг	3,702,920.2	4,319,122.6
Хяналтын эрхгүй хувь		3,678,284.3
Оролцоонд ногдох		
Хуримтлагдсан ашиг	15,242,394.4	13,075,920.6
<i>Дүн (мянган төгрөг)</i>	<i>43,416,706.1</i>	<i>44,038,349.9</i>

Компанийн хувийн өмч нь "Дархан нэхий" ХК-аас хөрөнгө оруулалтаар шилжиж ирсэн хөрөнгүүдийн нийлбэрээс бүрдэж байна.

а). Үндсэн үйл ажиллагааны орлого

Үзүүлэлт	2018.12.31	2019.12.31
1. Оёмол бүтээгдэхүүн	5,717,132.0	5,232,698.0
2. Гутал	3,590,345.6	3,353,364.8
3. Арьс шир	5,084,181.0	3,368,763.0
4. Хүнс	7,134,802.1	5,520,627.0
5. Үйлчилгээ	495,641.8	644,917.6
6. Байр	881,594.8	1,112,461.2
7. Түрээсийн орлого	638,994.6	732,923.3
8. Хүүгийн орлого	620,222.1	384,451.6
9. Химийн материал борлуулсаны	271,905.6	958,013.6
10. Бусад орлого	164,103.6	294,989.4
<i>Цэвэр борлуулалт (мянган төгрөг)</i>	<i>24,598,923.2</i>	<i>21,603,211.5</i>

Нийт борлуулалтын орлогод дотоодын болон экспортын орлогыг харьцуулбал дараах байдалтай байна.

Үзүүлэлт	2018.12.31	2019.12.31
1. Дотоодын борлуулалтын орлого	22,779,918.5	20,428,234.7
2. Экспортын борлуулалтын орлого	1,819,004.7	1,174,976.8
<i>Дүн (мянган төгрөг)</i>	<i>24,598,923.2</i>	<i>21,603,211.5</i>

б). Борлуулсан бүтээгдэхүүний өртөг

Үзүүлэлт	2018.12.31	2019.12.31
1. Оёмол бүтээгдэхүүн	4,083,089.0	3,419,344.5
2. Гутал	2,576,693.3	2,619,920.0
3. Арьс шир	5,512,136.6	2,652,181.6
4. Хүнс	4,745,379.7	3,254,813.1
5. Ресторан	183,909.1	296,893.9
6. Байрны борлуулалт		783,877.4
7. Химийн материал	263,357.1	749,268.8
<i>Дүн (мянган төгрөг)</i>	<i>17,364,564.8</i>	<i>13,776,299.3</i>

в). Үйл ажиллагаа (борлуулалт болон ерөнхий удирдлага)-ны зардал

Зардлын зүйл	Тайлант жил		Зөрүү
	2018.12.31	2019.12.31	
Үндсэн болон нэмэгдэл цалин	1,606,616.2	1,562,476.3	(44,138.9)
Нийгмийн даатгалын шимтгэл	169,499.3	202,782.3	33,283.0
Засвар үйлчилгээний зардал	123,299.6	119,935.6	(3,364.0)
Ашиглалтын зардал	159,958.0	186,097.9	26,139.9
Түрээсийн зардал	90,538.8	22,769.8	(67,769.0)
Албан томилолтын зардал	8,618.1	11,017.3	2,399.2
Тээврийн зардал	53,735.0	56,956.5	3,221.5
Элэгдэлийн зардал	1,165,816.0	1,346,187.2	180,371.2
Зар суртчилгааны зардал	51,161.6	86,077.7	34,916.1
Шуудан холбооны зардал	22,655.3	25,007.1	2,351.8
Бичиг хэргийн зардал	8,234.2	7,641.5	592.7
Шатахууны зардал	38,417.6	19,949.9	(18,467.7)
ҮХХ, газрын татварын зардал	23,054.4	338,583.7	315,529.3
Зээлийн хүүгийн зардал	774,348.4	839,604.0	65,255.6
Зээлийн эрсдлийн зардал	71,049.4	215,992.8	144,943.4
Бусад зардал	705,754.0	404,529.0	(301,225.0)
<i>Дүн (мянган төгрөг)</i>	<i>5,072,755.9</i>	<i>5,445,608.6</i>	<i>372,852.7</i>


Үйл ажиллагааны зардлын 32.4 хувийг цалин, НДШ-ийн зардал, 19.4 хувийг зээлийн хүүгийн зардал, зээлийн эрсдлийн зардал, 48.2 хувийг ашиглалт, түрээс, шуудан холбоо, тээвэр, албан томилолт, зар сурталчилгаа, бичиг хэрэг, засвар үйлчилгээ, албан татвар, бусад зардал, элэгдлийн зардал тус тус эзэлж байна.

Үйл ажиллагааны зардал өмнөх оноос 6.8 хувь буюу 372,852.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

д). Үндсэн бус үйл ажиллагааны зардал

Үзүүлэлт	2019.12.31	Хувиар
Ажлын байрны засвар	90,259.5	37.2
Хоол унааны хөнгөлөлт	110,448.0	45.5
Сургалт семинар	5,814.7	2.4
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	36,047.0	14.9
<i>Дүн (мянган төгрөг)</i>	<i>242,569.2</i>	<i>100.0</i>

Үйл ажиллагааны бус зардлын 37.2 хувийг засварын зардал, 45.5 хувийг ажилчдын хоол унааны хөнгөлөлтийн зардал, 2.4 хувийг сургалтын зардал, 14,9 хувийг үндсэн хөрөнгө данснаас хассан гарз тус тус эзэлж байна.



“ДАЛАЙВАН АУДИТ” ХХК
ДАРХАН-УУЛ АЙМАГ
МОНГОЛ УЛС

2020 ОНЫ 2 ДУГААР
САРЫН 14 ӨДӨР



ДАЛАЙВАН АУДИТ

Аудит, багааргаажуулах, өөрчлөлийн болон
бизнесийн үйлчилгээ, нийлэх үйлчилгээ

Монгол Улс, Улаанбаатар хот-16166
Баннгал дүүрэг, Амарсанаагийн гудамж-5
Утас: 70005401, 70005404, 70005405
Факс: 1976-70005403
Э-Шуудан: info@dalaivanaudit.mn
Вэб хуудал: www.dalaivanaudit.mn

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

ДАРХАН НЭХИЙ ХК-ИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДЭД

Хязгаарлалтгүй санал дүгнэлт

Бид 2019 оны 12 дугаар сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдолтой нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн Дархан нэхий ХК-ийн (РД:2649624) санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр Дархан нэхий ХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны орлого үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад нийцүүлэн Сангийн Сайдаас баталж, гаргасан журам зааврын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Энэ стандартын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү тайлангийн санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу үйлчлүүлэгчээс хараат бус байх, эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагуудыг мөрдөж ажилласан.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргахад хангалтай бөгөөд зохистой гэж бид үзэж байна.

Санхүүгийн тайлангийн талаар удирдлага болон засаглах удирдлагын хүлээх хариуцлага

Удирдлага нь СТОУС-ын дагуу санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэг хүлээхээс гадна залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд зайлшгүй чухал гэж тодорхойлсон дотоод хяналтуудыг тодорхойлно.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага компанийн үйл ажиллагааг төлбөрийн чадваргүй болох эсвэл үйл ажиллагаа зогсоох, ингэхээс өөр сонголтгүй байхаас бусад тохиолдолд удирдлага санхүүгийн тайлангаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх хариуцлагыг хүлээх ба тасралтгүй байдалтай холбоотой асуудлууд болон нягтлан бодох бүртгэлд ашигласан тасралтгүй байдлын суурийн талаар нэмэлт тодруулга хийнэ.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН
(үргэлжлэл)

Компанийн засаглах удирдлага нь санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүргийг хүлээнэ.


Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй бэлтгэгдсэн эсэх талаар хамгийн боломжит баталгааг олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх явдал юм. Хамгийн боломжит баталгаа гэдэг нь дээд түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа буруу тайлагнал бүрийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгааг өгөхгүй юм. Залилан эсвэл алдаанаас шалтгаалан буруу тайлагнал үүсэж болох ба дангаараа эсвэл нийтдээ материаллаг гэж үзсэн бол санхүүгийн тайланд тулгуурлан хэрэглэгчийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх боломжтой юм.

Гүйцэтгэх удирдлагатай харилцсаны үндсэн дээр бид тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитаар хамгийн чухал гэж авч үзсэн асуудлуудыг тодорхойлж аудитын гол асуудлууд гэж үзсэн. Бид олон нийтэд мэдээлэх нь сөрөг үр дагаврыг авчрах учраас хууль тогтоомжоор хориглосон байдаг асуудлаас бусад аудитын асуудлуудыг аудиторын тайландаа харуулсан.

Бусад

Энэхүү тайланг Компанийн тухай хуулийн 94 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох компанийн хувьцаа эзэмшигчдийн хүсэлтийн дагуу бэлтгэсэн ба тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа гуравдагч талын өмнө ямар нэг хариуцлага хүлээхгүй болно.



ДАЛАЙВАН АУДИТ ХХК
УЛААНБААТАР ХОТ
МОНГОЛ УЛС

2020 ОНЫ 2 ДУГААР
САРЫН 14-НЫ ӨДӨР

САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

2019 оны 12-р сарын 31-ний өдөр

(мян.төг)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Хөрөнгө		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1,140,899.40	458,005.70
Дансны авлага	4,299,745.00	6,254,458.80
Татвар, НДШ-ийн авлага	95,938.50	192,103.60
Бусад авлага	471,077.60	134,037.80
Бараа материал	12,959,297.50	14,886,578.60
Урьдчилж төлсөн зардал	230,125.60	310,034.80
Бусад эргэлтийн бус хөрөнгө	148,617.90	641,784.30
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө		3,354,133.80
Эргэлтийн хөрөнгийн дүн	19,345,701.50	26,231,137.40
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	28,356,183.10	27,968,307.40
Биет бус хөрөнгө	24,999.30	45,552.80
Биологийн хөрөнгө	400.00	
Урт хугацаат хөрөнгө оруулалт	1,690,220.00	1,000.00
Дуусаагүй барилга	6,222,867.90	9,031,468.00
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	36,294,670.30	37,046,328.20
Нийт хөрөнгийн дүн	55,640,371.80	63,277,465.60
Өр төлбөр ба эздийн өмч		
Өр төлбөр		
Дансны өглөг	1,377,965.70	1,311,720.50
Цалингийн өглөг	3,751.00	145,350.50
Татварын өр	889,542.30	2,028,053.90
НДШ-ийн өглөг	98,281.30	434,025.90
Богино хугацаат зээл	1,987,312.00	1,199,040.80
Бусад богино хугацаат өр	8,052.60	31,959.30
Урьдчилж орсон орлого	1,585,766.50	3,793,916.10
Нөөц(өр төлбөр)	22,994.30	
Урт хугацаат өглөг	6,250,000.00	10,295,048.70
Өр төлбөрийн нийт дүн	12,223,665.70	19,239,115.70
Эздийн өмч		
Өмч:-Хувийн	5,259,944.00	3,753,574.90
Халаасны хувьцаа	(16,428.50)	(16,428.50)
Нэмэгдэж төлөгдсөн капитал	(106,648.60)	(106,648.60)
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	19,334,524.60	19,334,524.60
Эздийн өмчийн бусад хэсэг	3,702,920.20	4,319,122.60
Хуримтлагдсан ашиг	15,242,394.40	13,075,920.60
Хяналтын эрхгүй хувь оролцоонд ногдох		3,678,284.30
Эздийн өмчийн дүн	43,416,706.10	44,038,349.90
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	55,640,371.80	63,277,465.60

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

2019 оны 12-р сарын 31-ний өдөр

(мян.төг)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Борлуулалтын орлого (цэвэр)	23,023,438.00	20,254,732.70
Борлуулалтын өртөг	17,364,564.80	13,776,299.30
Нийт ашиг	5,658,873.20	6,478,433.40
Түрээсийн орлого	29,760.10	669,037.80
Хүүний орлого	620,222.10	384,451.60
Ногдол ашгийн орлого		
Эрхийн шимтгэлийн орлого	925,503.00	294,989.50
Бусад орлого	5,378,367.70	4,918,464.70
Ерөнхий ба удирдлагын зардал	172,058.30	86,077.70
Борлуулалт маркетингийн зардал		
Санхүүгийн зардал	442,948.40	441,066.20
Бусад зардал	8,823.00	(10,073.10)
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(1,087.80)	36,047.00
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	(80,857.80)	206,522.20
Бусад ашиг алдагдал	1,167,861.40	2,613,799.80
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	116,786.10	286,166.40
Орлогын татварын зардал	1,051,075.30	2,327,633.40
Татварын дараах ашиг (алдагдал)		
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг	1,051,075.30	2,327,633.40
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		
Бусад дэлгэрэнгүй орлого		
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
Бусад олз (гарз)		
Орлогын нийт дүн		
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙНТАЙЛАН
2019 оны 12-р сарын 31-ний өдөр

(Мянг төг)

Төрөл	Өмч	Хатгааны хувьцаа	Нэмэгдэж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эдийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Хяналтын эрхгүй хувь оролцоо	Нийт дүн
2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	5,226,944.00	(16,428.50)	(106,648.60)	19,334,524.60	3,712,045.00	14,764,506.70	299,575.60	43,234,518.60
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлттэй нөлөө, алдааны залруулга								
Залруулсан үлдэгдэл								
Тайлант үеийн цэвэр ашиг							1,051,075.30	1,051,075.30
Бусад орлого								
Өмчид гарсан өөрчлөлт	33,000.00				(9,124.90)	457,887.70		481,762.80
2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	5,259,944.00	(16,428.50)	(106,648.60)	19,334,524.60	3,702,920.10	15,242,394.40	1,350,650.90	44,767,356.90
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлттэй нөлөө, алдааны залруулга								
Залруулсан үлдэгдэл								
Бусад орлого								
Тайлант үеийн цэвэр ашиг							2,327,633.40	2,327,633.40
Өмчид гарсан өөрчлөлт								
Зарласан ногдол ашиг								
2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	3,733,574.90	(16,428.50)	(106,648.60)	19,334,524.60	4,319,122.60	13,075,920.60	3,678,284.30	44,039,349.90

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2019 оны 12-р сарын 31-ний өдөр

(мян.төг)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн орлого	1,141,885.20	2,306,901.10
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого	993,679.20	2,227,109.40
Татаас, санхүүжилтын орлого		
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгөн	148,206.00	79,791.70
Бусад орлого		
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн зардал	1,157,571.90	2,240,309.90
Ажиллагсад олгосон мөнгө	37,938.00	45,779.10
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	9,082.50	12,919.50
Бараа материал худалдан авахад төлсөн мөнгө	941,441.20	2,104,006.30
Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	1,408.40	
Түлш, шатахуун, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	6,127.40	885.00
Хүүний төлбөрт төлсөн		
Татварын байгууллагад төлсөн мөнгө	3,345.50	4,541.10
Даатгалын төлбөрт төлсөн	158,228.90	72,178.90
Бусад зардал		
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(15,686.70)	66,591.20
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого	30,000.00	
Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө		
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
Хүлээн авсан хүүний орлого	5.60	24.30
Бусад		
Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ	30,005.60	24.30
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		181,618.40
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	186,486.00	
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
Авлагын цугларалт		
Төрөл бүрийн хандив		
Хөрөнгө борлуулсаны орлого		
Бусад		
Санхүүгийн цэвэр мөнгөн гүйлгээ	(186,486.00)	(181,618.40)
Валютын ханшийн зөрүү		
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(172,167.10)	(682,893.70)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	303,042.00	1,140,899.40
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	130,874.90	458,005.70